



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/310

Баруун-Урт сум

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17.1, 19.17.2, Эрүүл мэнд, спортын сайдын 2021 оны Журам шинэчлэн батлах тухай 400 дугаар тушаал, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан ЭЭС/10/19/43 дугаартай тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй Эрдэнэцагаан сумын "Хатанцагаан тун" эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгасугай.

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл комиссын дарга (П.Болормаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



М.ИДЭРБАТ